



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 91


Улаанбаатар хот

“Хаан даатгал” ХХК-д жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12<sup>1</sup>.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 302 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хаан даатгал” ХХК-д жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.
2. Даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдэлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Хаан даатгал” ХХК /Ч.Мягмарсүрэн/-д үүрэг болгосугай.
3. Салбараа нээгээгүй аймагт жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагааг аливаа хэлбэрээр эрхлэн явуулахыг “Хаан даатгал” ХХК-д хориглосугай.
4. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж, “Хаан даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан албан журмын даатгалын хэлбэрийг нэмж бүртгэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000115